



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн эрүүл мэндийн газар, АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран “Мэдээнд статистик боловсруулалт, дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох” сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, тайланг ирүүлэхийг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /Ж.Тогтохбаяр/-д үүрэг болгосугай.

3. Сургалтын зардалд шаардагдах 2,450,000 /хоёр сая дөрвөн зуун тавин мянга/-н төгрөгийг төсвийн зохих зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА



420240



## **“МЭДЭЭНД СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ТООЦОХ” СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

### **Үндэслэл:**

Эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн ажилтнуудын өдөр тутам гаргадаг мэдээ мэдээллийг хөнгөвчлөх, мэдээ мэдээллийн үнэн бодитой байлгах, хяналт үнэлгээ хийж бодлого боловсруулагч шийдвэр гаргагч нарт үндэслэлтэй мэдээлэл өгч байх шаардлага зүй ёсоор тавигддаг.

Эрүүл мэндийн яамнаас 2017 онд салбарын тэргүүлэх чиглэлийг Нийгмийн эрүүл мэнд жил болгосонтой холбоотой халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Халдварт бус өвчний эрт илрүүлэг, мэдээ, мэдээллийн тогтолцоог үндэсний түвшинд амжилттай хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж, ялангуяа бага насны хүүхдэд төрөлхийн хэлбэрээр илүүтэй бүртгэгдэж байна. Төрөөс нийгмийн хамгааллын олон талт бодлогын арга хэмжээ авч байгаа боловч хүүхдийг бага насанд нь эрт илрүүлэх тогтолцоотой болох нь нэн тэргүүний асуудал болж байна. Тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл, эндэгдэлд төрөлхийн гажиг тэргүүлэх шалтгаануудын нэг төдийгүй жил тутам нийслэл Улаанбаатар хотод 5000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүн шинээр бүртгэгдсэний 800 хүүхэд буюу 16 хувь нь 5 хүртэлх насны хүүхэд байна. Иймд мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрт илрүүлэх тогтолцоог бий болгох, бүртгэлийн маягтыг шинэчлэх шаардлагын үндсэн дээр энэхүү судалгааг явуулах шаардлагатай байна.

### **Зорилго:**

Бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бий болгоход илрүүлгийн өгөгдөл, үр дүнг тооцох аргачлалд суралцах, мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээний нэгдсэн сан үүсгэх.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** ЭМХТ,НЭМГ, АШУҮИС-ийн НЭМС

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2017 оны 03 сарын 24 ны өдөр,

**Оролцогч талууд:** Дүүргийн ЭМТ-ийн статистикч эмч, Өрхийн ЭМТ-ийн мэдээлэл хариуцсан ажилтан

**Хүлээгдэж байгаа үр дүн:**

1. Статистик боловсруулалт, үр дүнг тооцох арга зүйд суралцсан байна
2. Мэдээг програмд оруулж, дүн шинжилгээ хийх аргад суралцсан байна
3. Нэгдсэн тайлагнах үйл ажиллагаа хийгдсэн байна
4. Эрт илрүүлгийн тогтолцооны судалгааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөгдсөн байна
5. Нэгдсэн мэдээний сан үүсгэгдсэн байна.




**“МЭДЭЭНД СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ  
ТООЦОХ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

<b>Өдөр</b>	<b>Хугацаа</b>	<b>Сэдэв</b>
<b>1-дэх өдөр</b>	8.40-9.00	Оролцогчдын бүртгэл
	9.00-9.10	Нээлтийн үйл ажиллагаа
	9.10-9.30	Танилцах үйл ажиллагаа
	9.30-9.50	Сургалтын зорилго, зорилтыг танилцуулах
	9.50-10.20	Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлгийн асуумжийн мэдээлэл оруулах, нэгтгэлийг хийх зохион байгуулалтын үйл ажиллагаа
	10.20-11.00	Судалгааны өгөгдөлийг програм дээр оруулах, үр дүнг тооцох, хүснэгт, график байгуулах
	11.00-11.10	<b>Цайны завсарлага</b>
	11.30-12.00	Асуумж судалгааг програм ашиглан оруулах, шалгах, дүн шинжилгээ хийх
	12.00-13.30	<b>Өдрийн хоол</b>
	13.30-14.00	9, 18 сартай хүүхдийн асуумжийн мэдээлэл оруулах, хянах, дүн шинжилгээ хийх
	14.00-14.40	Дадлага ажил /асуумжийг програмд оруулах, тестлэх/
	14.40- 15.00	2, 3 настай хүүхдийн асуумжийн мэдээлэл оруулах, хянах, дүн шинжилгээ хийх
	15.00-15.30	Дадлага ажил /асуумжийг програмд оруулах, тестлэх/
	15.10-15.30	<b>Цайны завсарлага</b>
	15.30-15.50	4, 5 настай хүүхдийн асуумжийн мэдээлэл оруулах, хянах, дүн шинжилгээ хийх
	15.50-16.10	Дадлага /асуумжийг програмд оруулах, тестлэх/
	16.10-16.50	Статистик боловсруулалт хийх, нэгтгэсэн үр дүнг тооцох, тайлагнах
	16.50-17.20	Асуулт, хариулт
	17.20	Хаалт



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий  
захирлын 2017 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн А/45 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**“МЭДЭЭНД СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ  
ТООЦОХ” СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Шаардлагатай зүйлс	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Бичиг хэргийн зардал	1 хүн	120	2000	240000
2.	Гэрчилгээ	1 хүн	120	1000	120000
3.	Цайны зардал	1 хүн/өдөр	120*2	2500	600000
4.	Хоолны зардал	1 хүн/өдөр	120	10000	1200000
5.	Багшийн цагийн хөлс /магистр/	хүн*цаг	1*8	10000	80000
6.	Багшийн цагийн хөлс /доктор/	хүн*цаг	1*8	20000	160000
7.	Бусад /хэвлэх олшруулах, ус/				50000
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>				<b>2450000</b>

Хянасан:

Д.Гантуяа /Ахлах нягтлан бодогч/

Боловсруулсан:

О.Баярсайхан

О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/